



**ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ**

2018 оны 10 сарын 04 өдөр

Дугаар 95

Мандалговь

**Үндсэн хөрөнгө дуудлагаар худалдах  
зөвшөөрөл олгох тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3 дахь хэсэг, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2018 оны 77 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсгийн 6.2.1, 6.4 дэх хэсгийн 6.4.1 дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлаас **ТОГТООХ НЬ:**

**Нэг:** Луус сумын Эрүүл мэндийн төвийн үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй нийт 18,300,000(арван найман сая гурван зуун мянга) төгрөгний анхны өртөгтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн УАЗ-315122 маркын ДУА 52-70 улсын дугаартай автомашиныг актлан нээлттэй дуудлага худалдаагаар худалдахыг зөвшөөрсүгэй.

**Хоёр:** Хөрөнгө худалдах үнийн доод хязгаарыг 2,000,000(хоёр сая) төгрөгөөр тогтоон нээлттэй дуудлага худалдааг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу зохион байгуулж, хөрөнгө худалдсанаас орох орлогыг 100 хувь Төрийн сангийн хөрөнгө борлуулсны орлогын 100080000962 тоот дансанд төвлөрүүлэхийг Орон нутгийн өмчийн газар /С.Ууганбаяр/-т үүрэг болгосугай.

**Гурав:** Эд хөрөнгийг худалдсаны дараа хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэхийг Луус сумын Эрүүл мэндийн төвийн дарга/ Г.Наранжаргал/-д даалгасугай.

**Дөрөв:** Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Орон нутгийн өмчийн газрын дарга / С.Ууганбаяр/-т үүрэг болгосугай.

ДАРГА

*(Handwritten signature and red official stamp)*

С.СҮХБААТАР